



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/01

Мандагговь


“Амьдралын зөв, дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” жил болгон зарлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, 2020-2024 онд хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Эрүүл идэвхтэй амьдрал 2021-2024 он арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” А/780 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт болон халдварт бус өвчлөлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлс болох буруу хоололт, хөдөлгөөний хомсдол, хорт зуршил, жингийн илүүдлээс сэргийлэх талаар иргэдийн эрүүл мэндийн боловсрол, ойлголт, хандлагыг өөрчилж, эрүүл зан үйл, амьдралын зөв, дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор 2023 оныг “Амьдралын зөв, дадал хэвшлийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” жил болгон зарласугай.

2. “Амьдралын зөв, дадал хэвшлийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж, биелэлт, үр дүнг тооцон ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга (Л.Ганбат), Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (Б.Саруулцэцэг), эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. “Амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” жилийн ажлын явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг эмнэлэг, эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд оруулан тооцож ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан), Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Оюунчимэг) нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.АЛТАНТӨГС